



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар A/25

Хэрлэн сум

Хэрлэнбаян-Улаан тосгоны сургууль,  
цэцэрлэгийн цогцолбор болгон өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6, 7.7 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн Дэлгэрхaan сумын Хэрлэнбаян-Улаан тосгоны сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг ерөнхий боловсролын байгууллагатай нэгтгэн сургууль, цэцэрлэгийн цогцолбор болгон өөрчилсүгэй.

2.Цогцолбор болгохтой холбогдуулан хэрэгжилтийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, багш, удирдлагыг арга зүйн зөвлөгөө, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханганд ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагч (Ж.Март)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

